



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/89

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 32.1.10, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн "Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 62 дугаар тогтоол", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор аймгийн аюулгүй нөөцөд өвс, худалдан авах зардалд шаардагдах 132,450,000 (нэг зуун гучин хоёр сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Хууль журмын дагуу гэрээ байгуулан ажиллаж, холбогдох зардал 97,450,000 (ерэн долоон сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлаас 35,000,000 (гучин таван сая) төгрөг тус тус гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном) зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Шуурхай штабын дарга (Б.Наранбаатар) дүүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400206